



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/138

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2, 30.1.16 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Төлөвлөгөө батлах тухай” 2021 оны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхэд хөгжил, хамгааллын жил болгон зарласантай холбогдуулан жилийн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын үнэлгээний төвтэй хамтран зохион байгуулж буй хичээлийн хоцрогдлыг арилгах зорилго бүхий “Суурь судалгаанд үндэслэсэн багшийн мэргэжил дээшлүүлэх” хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах сургагч багшийн сургалтын зардалд 1190000 (нэг сая нэг зуун ерэн мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010378